



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2023 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 261628 Цахим хаяг: Erdenechimegda@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15150 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс 51 26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.НЯМХҮҮ ТАНАА

2023.02.24 № 07/366
тавай _____ -ныг № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2022 онд болсон 77 дугаар чуулганы үеэр UNESCO, UNICEF хамтарч Gateways to Public Digital Learning санаачилгыг зарлаж, тэргүүлэгч улсуудын жагсаалтад Монгол, Аргентин, Испани, Швейцарын холбооны улс, Арабын нэгдсэн Эмират улсуудыг нэрлэсэн байна. Монгол Улсын боловсролын салбар цахим шилжилтээрээ дэлхийд эхний 5 орны тоонд нэрлэгдэхэд Боловсролын мэдээллийн технологийн төвийн инженер, техник, мэдээллийн технологийн ажилтнуудын судалгаа, хөгжүүлэлтийн ажлын үр дүнд "Medle" цахим сургуулийг байгуулж, виртуал ертөнц дэх цахим хаалгаа нээсэн нь голлон нөлөөлсөн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сонгон судлах хичээлийг хэрэгцээ, сонирхолдоо тулгуурлан сонгохоор заасан боловч судлах нөхцөл нь бүрдээгүй сурагчдад "Medle" цахим сургууль тэгш боломжийг бүрдүүлсэн байна. Энэ сургалтад 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын 500 сургуулийн 10 дугаар ангид суралцдаг 9,590 сурагч 16 судлагдахууны 620 бүлгээр суралцаж, 153 багш ажиллаж байна.

Мөн сургалтын цахим контент хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглалт хэрэглээг дэмжих, тогтвортой ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд үндэсний сургалтын хөтөлбөрт нийцсэн "Ерөнхий боловсролын 1-12 дугаар ангийн 5123 хичээлийн контентыг сонгон шалгаруулж Medle.mn цахим санд байршуулж, 1-9 ангийн хичээлийг 100 хувь цахимаар судлах боломжийг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Боловсролын чанарын шинэчлэл төсөл"-ийн "Дасгал ажлын дэвтрийг интерактив онлайн хувилбарт хөрвүүлэх" арга хэмжээний хүрээнд системийн гарын авлага, видео зааврыг бэлтгэн help.esis.edu.mn системд байршуулж, 273,149.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын Боловсрол, шинжлэх ухааны сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 97.0 хувь хэрэгжсэн, тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 91.7 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-----------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I) | 287,468,448.15 | 179,711,303.51 |
| 33 | АВЛАГА | 478,500.34 | 16,661,329.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 478,500.34 | 787,138.00 |
| 33101 | Цалингийн авлага | 0.00 | 787,138.00 |
| 33102 | НДШ-ийн авлага | 478,500.34 | 0.00 |
| 33500 | Бусад авлага | 0.00 | 15,874,191.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 6,615,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 0.00 | 9,259,191.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 286,989,947.81 | 163,049,974.51 |
| 35400 | Хангамжийн материал | 286,989,947.81 | 163,049,974.51 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,738,364.01 | 4,538,340.01 |
| 35420 | Аж ахуйн материал | 135,270.00 | 1,879,670.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 263,971,170.00 | 104,948,634.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,700,743.80 | 2,130,680.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,444,400.00 | 49,552,650.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | 5,297,014,397.47 | 6,560,638,039.98 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,297,014,397.47 | 6,560,638,039.98 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,390,828,889.53 | 4,057,280,960.39 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 28,020,000.00 | 0.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (8,172,500.00) | 0.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 10,372,277,262.00 | 8,719,862,554.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (8,021,277,946.13) | (5,191,629,180.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 25,761,118.66 | 58,343,470.66 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (10,889,600.55) | (14,995,883.60) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,740,000.00 | 0.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | (629,444.45) | 0.00 |
| 39217 | Номын фонд | 0.00 | 485,700,000.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 2,906,185,507.94 | 2,503,357,079.59 |
| 39301 | Программ хангамж | 3,506,286,761.78 | 3,720,564,226.78 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж | (831,718,226.84) | (1,217,911,147.51) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 308,529,320.00 | 880,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад биет бус хөрөнгө | (76,912,347.00) | (175,999.68) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II) | 5,584,482,845.62 | 6,740,349,343.49 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV) | 974,600.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V) | 5,583,508,245.62 | 6,740,349,343.49 |

**Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | |
|-----------|---|-------------------------|-------------------------|
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,583,508,245.62 | 6,740,349,343.49 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 142,200,008.65 | 142,200,008.65 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 142,200,008.65 | 142,200,008.65 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 5,441,308,236.97 | 6,598,149,334.84 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 6,607,921,548.52 | 5,443,497,619.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (1,166,613,311.55) | 1,154,651,715.62 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V) | 5,584,482,845.62 | 6,740,349,343.49 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-----------|--|--------------------------|--------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 10,116,954,529.32 | 11,162,890,287.81 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,490,444,818.32 | 1,116,592,987.81 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 1,490,444,818.32 | 1,116,592,987.81 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,430,800.00 | 80,532,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 0.00 | 10,445,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 18,430,800.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0.00 | 63,744,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,472,014,018.32 | 1,035,403,487.81 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 0.00 | 7,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 8,626,509,711.00 | 10,046,297,300.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 8,235,737,300.00 | 9,773,147,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 8,235,737,300.00 | 9,773,147,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 390,772,411.00 | 273,149,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 90,000,000.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 299,683,411.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,089,000.00 | 273,149,400.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 11,213,503,341.87 | 9,940,684,628.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 11,213,503,341.87 | 9,940,684,628.60 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 10,672,313,452.39 | 9,232,379,810.92 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,488,767,766.83 | 2,175,727,986.17 |
| 210101 | Үндсэн цалин | 1,402,680,906.83 | 1,501,626,823.76 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 108,580,441.65 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 63,910,801.00 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 86,086,860.00 | 501,609,919.76 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 189,288,053.25 | 270,296,171.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 142,783,443.19 | 195,063,047.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,728,205.32 | 19,428,885.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,399,877.90 | 15,482,627.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,277,220.45 | 3,480,227.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,099,306.39 | 36,841,383.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 178,855,331.92 | 251,306,121.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,892,827.19 | 6,026,121.52 |

**Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | |
|----------|--|---------------------------|-------------------------|
| 210302 | Түлш, халаалт | 216,591.41 | 0.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 263,246.32 | 0.00 |
| 210304 | Байрны түрээс | 176,482,667.00 | 245,280,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,782,022.97 | 171,211,280.91 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,659,155.99 | 10,526,634.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,687,456.20 | 8,559,903.30 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,719,720.78 | 2,006,211.61 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 82,500.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,133,190.00 | 7,662,990.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 0.00 | 142,455,542.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,952,550.00 | 0.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,952,550.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,000,000.00 | 0.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,089,220.00 | 12,453,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,089,220.00 | 12,453,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,195,060,229.10 | 4,134,936,414.03 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,015,189,622.04 | 4,134,604,215.03 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,800,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 178,000,000.00 | 332,199.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 70,607.06 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,570,518,278.32 | 2,216,448,736.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,390,600.00 | 232,707,752.36 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 3,568,127,678.32 | 1,983,740,983.96 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 541,189,889.48 | 708,304,817.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,750,000.00 | 15,100,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 8,700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,750,000.00 | 6,400,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 539,439,889.48 | 693,204,817.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 491,055,399.46 | 693,204,817.68 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 48,384,490.02 | 0.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (1,096,548,812.55) | 1,222,205,659.21 |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 70,064,499.00 | 67,553,943.59 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 70,064,499.00 | 67,553,943.59 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 70,064,499.00 | 67,553,943.59 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V) | (1,166,613,311.55) | 1,154,651,715.62 |

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-----------|--|-------------------------|--------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 8,722,506,374.95 | 10,056,742,800.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 18,395,800.00 | 10,445,500.00 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 18,395,800.00 | 10,445,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,395,800.00 | 10,445,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | | 10,445,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 18,395,800.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 8,704,110,574.95 | 10,046,297,300.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 8,235,737,300.00 | 9,773,147,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 8,235,737,300.00 | 9,773,147,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 468,373,274.95 | 273,149,400.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 142,767,200.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 299,683,411.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,922,663.95 | 273,149,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 7,941,485,491.70 | 7,843,161,100.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 7,941,485,491.70 | 7,843,161,100.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,400,295,602.22 | 7,134,856,282.32 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,487,793,166.83 | 2,177,437,070.19 |
| 210101 | Үндсэн цалин | 1,401,706,306.83 | 1,501,426,735.14 |
| 210102 | Нэмэгдэл | | 108,580,441.65 |
| 210104 | Урамшуулал | | 63,910,801.00 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 86,086,860.00 | 503,519,092.40 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 189,766,553.59 | 269,870,325.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 143,261,943.53 | 194,789,450.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,728,205.32 | 19,390,502.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,399,877.90 | 15,452,047.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,277,220.45 | 3,472,730.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,099,306.39 | 36,765,593.32 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 178,855,331.92 | 251,306,121.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,892,827.19 | 6,026,121.52 |
| 210302 | Түлш, халаалт | 216,591.41 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | 263,246.32 | |
| 210304 | Байрны түрээс | 176,482,667.00 | 245,280,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 45,671,780.78 | 19,421,801.61 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,308,100.00 | 3,671,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,890,600.00 | 3,989,840.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,719,720.78 | 2,006,211.61 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 82,500.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,170,860.00 | 9,253,850.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 28,305,850.00 | 39,852,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,305,850.00 | 39,852,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,000,000.00 | |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,089,220.00 | 21,712,291.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,089,220.00 | 21,712,291.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,467,813,699.10 | 4,144,008,914.03 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,287,943,092.04 | 4,143,676,715.03 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,800,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 178,000,000.00 | 332,199.00 |

**Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | |
|-----------|--|-------------------------|---------------------------|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 70,607.06 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 211,247,758.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 211,247,758.36 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 541,189,889.48 | 708,304,817.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,750,000.00 | 15,100,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 8,700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,750,000.00 | 6,400,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 539,439,889.48 | 693,204,817.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 491,055,399.46 | 693,204,817.68 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 48,384,490.02 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II) | 781,020,883.25 | 2,213,581,700.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 781,020,883.25 | 2,213,581,700.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 781,020,883.25 | 2,213,581,700.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 781,020,883.25 | 2,213,581,700.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 781,020,883.25 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 781,020,883.25 | 2,213,581,700.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V) | (781,020,883.25) | (2,213,581,700.00) |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|----------------------------------|-----------------------|----------------------|--|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 142,200,008.65 | | 6,607,921,548.52 | 6,750,121,557.17 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 142,200,008.65 | | 6,607,921,548.52 | 6,750,121,557.17 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | | | (1,166,613,311.55) | (1,166,613,311.55) |
| 4 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 142,200,008.65 | 0.00 | 5,441,308,236.97 | 5,583,508,245.62 |
| 5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 2,189,382.25 | 2,189,382.25 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 142,200,008.65 | | 5,443,497,619.22 | 5,585,697,627.87 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 1,154,651,715.62 | 1,154,651,715.62 |
| 8 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 142,200,008.65 | | 6,598,149,334.84 | 6,740,349,343.49 |

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|---|-------------------------|-------------------------|-----------------------|-------------|
| 12 | Татварын бус орлого | 9,916,194,900.00 | 9,090,388,582.32 | 825,806,317.68 | 91.7 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 10,440,000.00 | 10,445,500.00 | (5,500.00) | 100.1 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 9,905,754,900.00 | 9,079,943,082.32 | 825,811,817.68 | 91.7 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 9,916,194,900.00 | 9,090,388,582.32 | 825,806,317.68 | 91.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 9,916,194,900.00 | 9,090,388,582.32 | 825,806,317.68 | 91.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГ | 9,899,294,900.00 | 9,075,288,582.32 | 824,006,317.68 | 91.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл үрэмшл | 2,070,158,500.00 | 1,934,205,192.19 | 135,953,307.81 | 93.4 |
| 210101 | Үндсэн цалин | 1,357,195,500.00 | 1,258,194,857.14 | 99,000,642.86 | 92.7 |
| 210102 | Нэмэгдэл | 100,000,000.00 | 108,580,441.65 | (8,580,441.65) | 108.6 |
| 210104 | Урамшуулал | 65,300,000.00 | 63,910,801.00 | 1,389,199.00 | 97.9 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 547,663,000.00 | 503,519,092.40 | 44,143,907.60 | 91.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл | 299,294,900.00 | 239,952,803.61 | 59,342,096.39 | 80.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 203,520,500.00 | 164,871,928.98 | 38,648,571.02 | 81.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,943,600.00 | 19,390,502.58 | 4,553,097.42 | 81.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,154,900.00 | 15,452,047.94 | 3,702,852.06 | 80.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,788,700.00 | 3,472,730.79 | 1,315,969.21 | 72.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 47,887,200.00 | 36,765,593.32 | 11,121,606.68 | 76.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 253,529,600.00 | 251,306,121.52 | 2,223,478.48 | 99.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,249,600.00 | 6,026,121.52 | 2,223,478.48 | 73.0 |
| 210304 | Байрны түрээс | 245,280,000.00 | 245,280,000.00 | | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 36,097,800.00 | 19,421,801.61 | 16,675,998.39 | 53.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,104,400.00 | 3,671,900.00 | 4,432,500.00 | 45.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,888,600.00 | 3,989,840.00 | 2,898,760.00 | 57.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,658,100.00 | 2,006,211.61 | 651,888.39 | 75.5 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,731,100.00 | 500,000.00 | 1,231,100.00 | 28.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,715,600.00 | 9,253,850.00 | 7,461,750.00 | 55.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,841,254,400.00 | 1,816,033,700.00 | 25,220,700.00 | 98.6 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 1,808,854,400.00 | 1,788,436,700.00 | 20,417,700.00 | 98.9 |
| 210602 | Тавилга | 32,400,000.00 | 27,597,000.00 | 4,803,000.00 | 85.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 50,456,400.00 | 21,712,291.00 | 28,744,109.00 | 43.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 50,456,400.00 | 21,712,291.00 | 28,744,109.00 | 43.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хургаамж | 4,574,233,800.00 | 4,154,508,914.03 | 419,724,885.97 | 90.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хургаамж | 4,566,872,200.00 | 4,154,176,715.03 | 412,695,484.97 | 91.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,361,600.00 | | 3,361,600.00 | |

**Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|-----------------------|--------------|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,000,000.00 | 332,199.00 | 3,667,801.00 | 8.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 774,269,500.00 | 638,147,758.36 | 136,121,741.64 | 82.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 774,269,500.00 | 638,147,758.36 | 136,121,741.64 | 82.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,900,000.00 | 15,100,000.00 | 1,800,000.00 | 89.3 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 8,700,000.00 | 8,700,000.00 | | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,200,000.00 | 6,400,000.00 | 1,800,000.00 | 78.0 |
| 3 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 9,916,194,900.00 | 9,090,388,582.32 | 825,806,317.68 | 91.7 |
| 310001 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 10,440,000.00 | 10,445,500.00 | (5,500.00) | 100.1 |
| 350001 | Төсвөөс санхүүжих | 9,905,754,900.00 | 9,079,943,082.32 | 825,811,817.68 | 91.7 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 41 | 39 | 2 | 95.1 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 40 | 38 | 2 | 95.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 39 | 37 | 2 | 95.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|--|------------|-----------------------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I) | | 273,149,400.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | 273,149,400.00 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 273,149,400.00 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 243,231,878.00 |
| Үндсэн цалин | | 243,231,878.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 29,917,522.00 |
| Тэтгэврийн даатгал | | 29,917,522.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II) | | 273,149,400.00 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 273,149,400.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 273,149,400.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 273,149,400.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар нийт 6,342.8 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар нийт 157,771.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 30,784.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тендерийг хугацаанд нь зохион байгуулж байх, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 126,987.2 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 157,771.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 169,253.5 мянган төгрөгөөс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өгсөн.

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-----|--|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|------------|---------|--------------|-----|---------|-----|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Дээд шатны байгууллагаас шилжүүлж авсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн бусад орлогоор зөрүүтэй бүртгэсэн. | 1 | 6,342.8 | | | 1 | 6,342.8 | 1 | 6,342.8 | | | | |
| | Дүн | 1 | 6,342.8 | | | 1 | 6,342.8 | 1 | 6,342.8 | | | | |

4.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|-----|--|-------------|----------|---------------|----------|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|---|---------------------|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| 1 | Гадаад томилолтын урьдчилгаа олгож, томилолтын ажлын гүйцэтгэл гараагүй, буцаан төлүүлээгүй, 15,874.191 төгрөгийн авлага үүсгэсэн байна. | 1 | 15,874.2 | 1 | 15,874.2 | | | | | | | | |
| 2 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулахад зориулан 4 хэвлэл мэдээллийн байгууллагатай | 1 | 14,910.0 | 1 | 14,910.0 | | | | | | | | |

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | | | |
|---|--|---|-----------|--|--|---|---|---|-----------|--|--|--|--|--|
| | гэрээ байгуулан 14,910,000.0 төгрөгийг зарцуулсан байна. | | | | | | | | | | | | | |
| 3 | Боловсролын мэдээллийн технологийн төв нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь зохион байгуулаагүй, тендер 2 удаа буцсан зэргээс 2022 оны 9 дүгээр сард Монголын Цахилгаан Холбоо ХК-тай "Боловсролын салбарын нэгдсэн сүлжээний тоон суваг, худаг сувагчлал, байр талбай түрээслэх" БМТТ/2021001А тоот гэрээ, Юнивишн ХХК-тай "Сүлжээний дэд бүтцийн ашиглалт, гэмтэл засварлах, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч" -ийн БМТТ/2021001Б тоот гэрээг тус тус байгуулахдаа гэрээ байгуулахаас өмнөх гэрээгүй хугацааны /5,6,7,8 дугаар сарын/ 778,176.2 мянган төгрөгийн төлбөрийг нөхөн тооцож олгосон нь сургуулиудын интернэтийн сүлжээний хэвийн ажиллагаа алдагдах, төсвийн хөрөнгө хяналтгүй, үр дүнгүй байх эрсдэлтэй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | | |
| 4 | Сангийн яамнаас байгуулсан ерөнхий гэрээний дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/492 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн сонгон суралцах хөтөлбөрийг онлайнээр зохион байгуулахад шаардлагатай 1,299,640.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч бэлтгэхдээ тайлант хугацаанд 126,987.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн нөөц үүсгэн, агуулахад бүртгэсэн байна. | 1 | 126,987.2 | | | | | 1 | 126,987.2 | | | | | |
| 5 | 2022 онд шинээр баригдсан 5 сургууль боловсролын нэгдсэн интернэтийн сүлжээнд холбогдоогүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | | |
| 6 | Сургалтын цахим контентын сан бүрдүүлэх хүрээнд Medle.mn-д 2022 онд 5123 буюу 485,700.0 мянган төгрөгийн контентийн зардлыг үндсэн хөрөнгийн | 1 | - | | | | | 1 | - | | | | | |

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | | |
|--|--|---|-----------|---|----------|---|---|---|-----------|--|--|--|--|
| | тайланд номоор бүртгэсэн байна. НБББББ-т цахим сургалтын гарын авлага болон бусад холбогдох зардлыг бүртгэх, тайлагнах талаар тусгаагүй байна. | | | | | | | | | | | | |
| | Дүн | 6 | 157,771.4 | 2 | 30,784.2 | 1 | - | 3 | 126,987.2 | | | | |

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|-----|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--|--|--|--|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| 1 | Засгийн газраас тогтоосон цалингийн сүлжээг мөрдөөгүй, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2021 оны А/278 тушаалаар баталсан албан тушаалын цалингийн сүлжээг мөрдсөн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | | | | |
| 2 | “Medle” нь үндэсний сургалтын хөтөлбөрийн дагуу орон даяар онлайн-сургалт зохион байгуулах Монголын анхны цахим сургууль хичээллэж байна. 2022-2023 оны хичээлийн жилээс Боловсролын мэдээллийн технологийн төвийн дэргэд сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлж буй “Medle” цахим сургуульд 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын 500 сургуулийн 10 дугаар ангид суралцдаг 9590 сурагч 16 судлагдахууны 620 бүлгээр суралцаж, 153 багш ажиллаж байгаа боловч сургуулийн бүтэц, чиглэл, статус батлагдаагүй, үндсэн, гэрээт багш нарын цалин, нийгмийн асуудал тодорхойгүй, зардлыг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаар баталж, зарцуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| | Дүн | 2 | - | - | - | - | - | 2 | - | | | | |

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР